



ХӨДӨЛМӨРИЙН НӨХЦЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙЛГЭХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Үйлчилгээг авснаар хийгдэх ажил, зорилго, үндэслэл:

- ХАБЭА-н тухай хуулийн дагуу Ажил олгогч нь ажлын байр шинээр бий болох болон тухайн ажлын байрны үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэл, нөхцөл өөрчлөгдлөх бүрт нь, химийн хорт болон аюулгүй бодис агуулсан түүхий эд, материал ашиглан үйл ажиллагаа явуулж байгаа бол жилд нэгээс доошгүй удаа ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх шаардлагыг хэрэгжүүлэх зорилготой.

2. Нийлүүлэгчид тавигдах шаардлага:

2.1. Нийлүүлэгчид тавигдах ерөнхий шаардлагын жагсаалт:

- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийх эрх бүхий байгууллага байна.
- Хөдөлмөрийн яамны харьяа байна.

2.2. Чанар, стандарт:

Монгол улсын хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийх журмын дагуу хийж гүйцэтгэх.

2.3. Нийлүүлэх бараа материалын үйлдвэрлэгдсэн улс, өмнө нийлүүлж байсан эсэх туршлагын талаарх мэдээлэл:

- Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүгнэлтийг бүх ажлын байр дээр гаргах, гаргасан дүгнэлт нь ямар ч нөхцөлд хүчин төгөдлөр байна.
- Урд онуудад МХЕГ, ХАБЭА-н төвөөр хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгүүлж байсан.

2.4. Хүний нөөцийн туршлагын шаардлага болон шаардлагатай тоног төхөөрөмжийн мэдээлэл, бусад үзүүлэлт:

- Хүний нөөцийн хувьд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийх эрүүл ахуйч нар нь мэргэжлийн, мэргэжлээрээ олон жил ажилласан туршлагатай бийх,
- Сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмжтэй байх, олон ажлын байруудад хэмжилт хийж гүйцэтгэх тул багажны тоо, ширхэг хүрэлцээтэй байх,

3. Шаардагдах баримт бичиг

3.1. Гүйцэтгэх ажлууд, ажил үйлчилгээний үе шатны хуваарь.

- Нийт ажлын байруудад хими / тоосны хэмжилт PM10, PM2.5, хорт хий, бусад / , физикийн / агаарын хэм, агаарын харьцангуй чийг, шуугиан, гэрэлтүүлэг, агаарын урсгалын хурд , доргио бусад/ хэмжилтүүдийг хийж гүйцэтгэх.
- Худалдан авах гэрээний дагуу ажлыг хийж гүйцэтгэх. Гэрээ байгуулагдсанаас хойш 10-20 хоногийн дотор хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийх.

3.2. Нийлүүлэгчээс шаардах тусгай зөвшөөрөл, стандартыг тогтоосон тусгай сертификат:

- Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй эрхтэй, мэргэжлийн байгууллага байх.

3.3. Энэхүү ажил үйлчилгээ, бараа материалыг авснаар гарах эдийн засгийн тооцоо болон судалгаа үр ашигтай байдлын талаарх мэдээлэл:

- Нийт ажлын байрны хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлж, хэвийн хэвийн бус ажлын байруудыг тодорхойлох.

3.4. Тухайн бараа материал, ажил, үйлчилгээнд шаардагдах захиалагчийн зүгээс зайлшгүй шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг болон нэмэлт шаардлагатай зүйлсийн талаарх мэдээлэл